



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнххаан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2022/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2022 он

Дарга,

тэргүүлэх аудитор:

М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Аудитын менежер:

Г.Даваа

Утас: 99035990 Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

Ахлах аудитор:

С.Ариунбаяр

Утас: 99076224 Цахим хаяг: [ariunbayars@audit.gov.mn](mailto:ariunbayars@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Төлбөрийн акт .....	14
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НББ	Нягтлан бодох бүртгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518398, Факс: 70518398  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Ауд. 02.25 № 56

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА С.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цалингийн зардлаас ажлын хөлс олгосон, өмнөх онд заруулсан бараа материалыг зарлагадаагүй, тушаал шийдвэргүй болон хүчингүй болсон тушаал баримтлан зарлага гаргасан, жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв бичээгүй, цалингийн урьдчилгаа суутган тооцоогүй, худалдан авсан материалыг данс бүртгэлд тусгаж зарцуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>88,155,985.91</u>	<u>89,820,875.00</u>
33	АВЛАГА	383,010.91	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	383,010.91	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	87,772,975.00	89,820,875.00
354	Хангамжийн материал	40,647,975.00	42,695,875.00
35410	Бичиг хэргийн материал	1,833,045.00	2,185,045.00
35420	Аж ахуйн материал	9,829,630.00	9,829,630.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	2,400,000.00
35470	Бусад хангамжийн материал	22,985,300.00	22,281,200.00
35600	Мал амьтад	47,125,000.00	47,125,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,384,297,993.46</u>	<u>1,798,148,640.51</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,384,297,993.46	1,798,148,640.51
392	Биет хөрөнгө	1,378,755,993.54	1,792,694,640.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	490,208,642.97	612,427,397.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	-37,500,877.16	-59,561,442.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	409,506,800.00	329,506,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-214,160,144.02	-179,585,899.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,347,599.40	89,687,599.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,434,495.05	-28,436,355.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,427,476.77	86,097,476.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,148,675.16	-21,545,991.82
39209	Зам, гүүрийн байгууламж	248,272,588.00	510,268,816.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-8,275,752.92	-33,103,011.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	744,393,664.00	838,820,084.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-352,080,833.29	-352,080,833.29
39217	Ном	200,000.00	200,000.00
393	Биет бус хөрөнгө	5,541,999.92	5,453,999.90
39301	Програм хангамж	2,386,500.00	2,386,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,858,500.08	-1,946,500.10
39303	Бусад биет бус хөрөнгө	5,014,000.00	5,014,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,472,453,979.37</u>	<u>1,887,969,515.51</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,472,453,979.37</u>	<u>1,887,969,515.51</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,472,453,979.37	1,887,969,515.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	271,947,945.17	272,003,945.17
51101	Өмч: - төрийн	271,947,945.17	272,003,945.17
512	Хуримтлагдсан үр дүн	1,128,873,891.95	1,544,333,428.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	415,459,536.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	71,632,142.25	71,632,142.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,472,453,979.37</u>	<u>1,887,969,515.51</u>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,120,568,730.29	1,188,001,318.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	415,383,874.29	423,211,403.50
120	Нийтлэг татварын бус орлого	415,383,874.29	423,211,403.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	415,383,874.29	423,211,403.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	705,184,856.00	764,789,914.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	268,888,549.00	210,070,214.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,055,286.00	32,035,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	251,832,168.00	100,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,748,595.00	75,695,014.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,252,500.00	2,340,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	436,296,307.00	554,719,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	436,296,307.00	554,719,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	840,020,764.35	772,541,781.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	840,020,764.35	772,541,781.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	834,851,401.28	732,080,626.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,895,364.02	285,315,628.94
210101	Үндсэн цалин	237,895,364.08	234,194,088.32
210102	Нэмэгдэл	00.00	16,318,800.00
210104	Урамшуулал	00.00	3,450,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,999,999.94	31,352,740.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,442,900.00	42,548,510.91
210201	Тэтгэврийн даатгал	23,965,900.00	29,643,436.02
210202	Тэтгэмжийн даатгал	2,567,300.00	2,922,574.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,953,900.00	1,877,634.96
210204	Ажилгүйдлийн даатгал	545,500.00	904,907.26
210205	Эрүүл мэндийн даатгал	5,410,300.00	7,199,957.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,500,000.00	23,947,695.07
210301	Гэрэл, цахилгаан	10,500,000.00	12,283,925.77
210302	Түлш, халаалт	10,000,000.00	10,163,769.30
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,146,150.00	49,233,792.00
210401	Бичиг хэрэг	3,507,950.00	3,404,550.00
210402	Тээвэр, шатахуун	36,572,100.00	36,924,777.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,580,000.00	2,870,390.00
210404	Ном, хэвлэл	685,100.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,801,000.00	6,034,075.00
2105	Нормативт зардал	6,316,000.00	14,352,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,765,000.00	14,050,000.00
210502	Хоол, хүнс	648,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	903,000.00	302,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,272,000.00	21,279,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,272,000.00	12,053,450.00
210604	Урсгал засвар	00.00	9,226,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,131,411.00	2,702,000.00
210702	Дотоод албан томилолт	2,131,411.00	2,702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,297,579.00	61,866,293.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,547,150.00	60,906,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,365,000.00	159,306.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,500.00	665,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	34,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	891,000.00	00.00
210807	Газрын төлбөр	126,129.00	35,907.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	413,849,997.26	230,834,756.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	277,503,118.00	131,632,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,065,500.00	5,402,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	132,281,379.26	93,800,756.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,169,363.07	40,461,155.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,993,400.00	6,743,400.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,993,400.00	6,193,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	550,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	175,963.07	33,717,755.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	175,963.07	33,717,755.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>280,547,965.94</u>	<u>415,459,536.14</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>280,547,965.94</u>	<u>415,459,536.14</u>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,947,945.17	74,057,666.98	847,843,277.29	1,193,848,889.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,425,524.73	2,425,524.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,947,945.17	74,057,666.98	850,268,802.02	1,196,274,414.17
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	280,547,965.94	280,547,965.94
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,947,945.17	71,632,142.25	1,128,873,891.95	1,472,453,979.37
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,947,945.17	71,632,142.25	1,128,873,891.95	1,472,453,979.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	00.00	00.00	00.00	00.00

	өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,947,945.17	71,632,142.25	1,128,873,891.95	1,472,453,979.37
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	56,000.00	00.00	00.00	56,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	415,459,536.14	415,459,536.14
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	272,003,945.17	71,632,142.25	1,544,333,428.09	1,887,969,515.51

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	705,184,856.00	764,789,914.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	705,184,856.00	764,789,914.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	268,888,549.00	210,070,214.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,055,286.00	32,035,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	251,832,168.00	100,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,748,595.00	75,695,014.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,252,500.00	2,340,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	436,296,307.00	554,719,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	436,296,307.00	554,719,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	705,064,856.00	680,349,914.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	705,064,856.00	680,349,914.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	694,895,492.93	639,888,759.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,278,374.93	285,315,628.94
210101	Үндсэн цалин	238,278,374.99	237,853,843.07
210102	Нэмэгдэл	00.00	16,318,800.00
210104	Урамшуулал	00.00	3,450,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,999,999.94	27,692,985.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,442,900.00	42,109,500.00
210201	Тэтгэврийн даатгал	23,965,900.00	28,630,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,567,300.00	3,066,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,953,900.00	1,856,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	545,500.00	891,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,410,300.00	7,666,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,500,000.00	23,947,695.07
210301	Гэрэл, цахилгаан	10,500,000.00	12,283,925.77
210302	Түлш, халаалт	10,000,000.00	10,163,769.30

210303	Цэвэр, бохир ус	00.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,642,870.00	49,435,792.00
210401	Бичиг хэрэг	3,869,690.00	3,796,550.00
210402	Тээвэр, шатахуун	32,718,180.00	36,924,777.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,600,000.00	2,870,390.00
210404	Ном, хэвлэл	990,100.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,464,900.00	5,844,075.00
2105	Нормативт зардал	3,208,000.00	14,866,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,560,000.00	13,900,000.00
210502	Хоол, хүнс	648,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	966,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,295,000.00	21,862,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,295,000.00	12,636,150.00
210604	Урсгал засвар	00.00	9,226,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,131,411.00	2,702,000.00
210702	Дотоод албан томилолт	2,131,411.00	2,702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,948,159.00	79,215,493.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,918,730.00	78,255,880.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,365,000.00	159,306.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,500.00	665,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	34,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,050,000.00	00.00
210807	Газрын төлбөр	246,129.00	35,907.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	275,448,778.00	120,434,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	271,448,778.00	115,032,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	5,402,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,169,363.07	40,461,155.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,993,400.00	6,743,400.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,993,400.00	6,193,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	550,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	175,963.07	33,717,755.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>120,000.00</u>	<u>84,440,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	120,000.00	84,440,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	120,000.00	84,440,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	120,000.00	84,440,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	120,000.00	84,440,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-120,000.00</u>	<u>-84,440,000.00</u>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		төлөвлөгөө	Гүйцэтгэл	

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	605441200.0	524774069.5	80667130.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	605441200.0	524774069.5	80667130.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	598653800.0	518030669.5	80623130.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	311922300.0	281244291.4	30678008.6
210101	Үндсэн цалин	265814400.0	237232505.6	28581894.4
210102	Нэмэгдэл	16318800.0	16318800.0	0.0
210105	Гэрээт ажлын хөлс	29789100.0	27692985.9	2096114.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42109500.0	42109500.0	0.0
210201	Тэтгэврийн даатгал	28630000.0	28630000.0	0.0
210202	Тэтгэмжийн даатгал	3066000.0	3066000.0	0.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1856000.0	1856000.0	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	891500.0	891500.0	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7666000.0	7666000.0	0.0
2103	Байр ашиглалттай холбоо тогтмол зардал	25900000.0	23947695.1	1952304.9
210301	Гэрэл, цахилгаан	12900000.0	12283925.8	616074.2
210302	Түлш, халаалт	11500000.0	10163769.3	1336230.7
210303	Цэвэр, бохир ус	1500000.0	1500000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	32276900.0	31291040.0	985860.0
210401	Бичиг хэрэг	3006800.0	3001550.0	5250.0
210402	Тээвэр, шатахуун	25030100.0	25030100.0	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3240000.0	2290390.0	949610.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1000000.0	969000.0	31000.0
2105	Нормативт зардал	1002000.0	966000.0	36000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1002000.0	966000.0	36000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90657500.0	48787650.0	41869850.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	39561900.0	39561150.0	750.0
210604	Урсгал засвар	51095600.0	9226500.0	41869100.0
2107	Томилолт, зочны зардал	6275400.0	2702000.0	3573400.0
210702	Дотоод албан томилолт	6275400.0	2702000.0	3573400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83108200.0	81580493.0	1527707.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80628400.0	80620880.0	7520.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	984400.0	159306.0	825094.0
210803	Даатгалын үйлчилгээ	235200.0	64350.0	170850.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1035600.0	665550.0	370050.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	106200.0	34500.0	71700.0
210807	Газрын төлбөр	80000.0	35907.0	44093.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	38400.0	0.0	38400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5402000.0	5402000.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5402000.0	5402000.0	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	6787400.0	6743400.0	44000.0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6193400.0	6193400.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	594000.0	550000.0	44000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	605441200.0	554719700.0	50721500.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	605441200.0	554719700.0	50721500.0
132001	Орон нутгийн төсвөөс	605441200.0	554719700.0	50721500.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	зөрүү
------------	----------	----------	-----------	-------

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		268,888,549.00	(268,888,549.0)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		268,888,549.00	(268,888,549.0)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		263,888,549.00	(263,888,549.0)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,312,000.00	(1,312,000.0)
210101	Үндсэн цалин		1,312,000.00	(1,312,000.0)
2104	Хангамж, бараа материалын зардал		5,822,180.00	(5,822,180.0)
210401	Бичиг хэрэг		325,000.00	(325,000.0)
210402	Тээвэр, шатахуун		4,218,180.00	(4,218,180.0)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,060,000.00	(1,060,000.0)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		219,000.00	(219,000.0)
2105	Нормативт зардал		2,208,000.00	(2,208,000.0)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,560,000.00	(1,560,000.0)
210502	Хоол, хүнс		648,000.00	(648,000.0)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,295,000.00	(3,295,000.0)
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,295,000.00	(3,295,000.0)
2107	Томилолт, зочны зардал		505,411.00	(505,411.0)
210702	Дотоод албан томилолт		505,411.00	(505,411.0)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		100,000.00	(100,000.0)
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		100,000.00	(100,000.0)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	250645958.00	(250,645,958.0)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		250,645,958.00	(250,645,958.0)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	5000000.00	(5,000,000.0)
2132	Бусад урсгал шилжүүлэг		5,000,000.00	(5,000,000.0)
213209	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		5,000,000.00	(5,000,000.0)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	268919249.00	(268,919,249.0)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		268,919,249.00	(268,919,249.0)
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		4,055,286.00	(4,055,286.0)
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		251,832,168.00	(251,832,168.0)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,748,595.00	(5,748,595.0)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		7,283,200.00	(7,283,200.0)

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнххаан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Ариунбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөнххаан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 1/57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай, хариуцлагатай хүргэж, ардчилсан зарчмыг баримталсан, мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны байгууллага болох зорилтыг дэвшүүлсэн байна.

Монгол улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуульд харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийн гүйцэтгэлд хяналт тавих, иргэдийн ирсэн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, мэдээллээр хангах зэрэг нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнххаан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 801,968.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,019.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,613.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнххаан сумын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 415,515.5 мянган төгрөгөөр буюу 28.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	383.0	-	(383.0)
Бараа материал	87,772.9	89,820.9	2,048.0
Үндсэн хөрөнгө	1,384,298.0	1,798,148.6	413,850.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,472,453.9</b>	<b>1,887,969.5</b>	<b>415,515.6</b>
Засгийн газрын хувь оролцоо	1,472,453.9	1,887,969.5	415,515.6
Тайлант үеийн үр дүн	-	415,515.6	415,515.6
<b>Өр төлбөр, цэвэр өмчийн дүн</b>	<b>1,472,453.9</b>	<b>1,887,969.5</b>	<b>415,515.6</b>

Бараа материал данс: Тайлант онд төсвийн хөрөнгөөр 141,129.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 139,082.0 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна. Бараа материал данс өмнөх оноос 2,048.0 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст сумын төвийн хашааг цэцэглэх өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор 2,400.0 мянган төгрөг зос /байгалийн будаа/ худалдан авч үлдэгдлээр тайлагнасан нь нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 413,850.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэ нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 84,400.0 мянга, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон олон улсын төсөл хөтөлбөрөөр 423,251.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч данс бүртгэлд тусгасан нь нөлөөлж байна. Мөн тайлант онд аймгийн ИТХ-ын шийдвэрээр 80,000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 605,441.2 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр

554,719.7 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ. Төсвийн гүйцэтгэлийг 524,774.1 мянган төгрөгөөр илэрхийлж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 29,945.6 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 323,353.8 мянган төгрөг буюу 61.6 хувийг цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл эзэлж байгаа бол 80,620.9 мянган төгрөг буюу 15.3 хувийг Засаг даргын нөөц сангийн зардалд зарцуулсан байна. Харин нийт зардлын 23.1 хувь болох 120,799.4 мянган төгрөгийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал зэрэг бусад зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.2 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Мөнххаан сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар 268,919.2 мянган төгрөг төвлөрч, 265,147.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 3,772.2 мянган төгрөгийг санхүүжүүлэгч байгууллагын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Мөнххаан сумын ЗДТГ нь 11 зорилтын хүрээнд 89 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 95.9 хувьтай тайлагнасан байна.

ЗДТГ нь сумын 1,486 өрхийн 5,040 иргэнд 23 төрлийн лавлагаа үйлчилгээ үзүүлдэг, статистикийн 16 төрлийн судалгаа, 9 төрлийн мэдээ гаргаж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал ажиглагдаагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 113 мэдээллийг хуулийн хугацаанд, 34 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Харин цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8 зарлагын гүйлгээний 210,000.0 мянга, урсгал санхүүжилтийн 37 гүйлгээний 691,437.5 мянган төгрөгийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,348.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 2,334.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, дотоод хяналт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 2 зөвлөмж хүргүүлж, шийдвэрийн биелэлтийг 2021 оны 275 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн боловч шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлэх талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 136,593.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 53,184.1 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 150.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 25,887.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 57,371.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг 10,072.2 мянган төгрөгийн тохируулах бичилт хийхгүйгээр /нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлага/ зардлыг илүү илэрхийлснийг тохируулж залруулав.
2. Бараа материалын тайланд 3,525.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг нэр төрөл тус бүрээр нь орлого зарлага гаргахгүйгээр бөөн дүнгээр нь тайлагнасныг эмийн нэр төрөл тус бүрээр нь тайланд залруулсан.
3. Тайлант оны эхэнд өвөлжилт, хаваржилт хүндэрч 16,600.0 мянган төгрөгийн өвсийг малчдад олгосон боловч санхүүгийн тайланд үлдээдлээр илэрхийлснийг анхан шатны баримтаар нь тулган зарлага болгов.
4. Үндсэн хөрөнгийн дансанд 19,988.9 мянган төгрөгийн зураг, төсвийг эдийн засгийн ангиллаар буруу бүртгэснийг данснаас хасуулж, тухайн хөрөнгө оруулалтын өртөгт шингээн бүтгэх зөвлөмж өгөө.
5. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3,000.0 мянган төгрөгийн худгийн тоног төхөөрөмжид тайлант оны элэгдэл бодогдоогүй байсныг тус тус залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Тайлант онд олгосон цалингийн урьдчилгаа 150.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй шууд зардалд илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>1</sup>, 41 дүгээр зүйлийн 41.2.3<sup>2</sup>-т заасныг зөрчиж үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

### 4.3 Албан шаардлага

1. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 20,000.0 мянган төгрөгийн фитнесийн тоног төхөөрөмж худалдан авч төсвийн хэмнэлт хийх горимыг зөрчсөн байна.
2. Худгийн ажилтны хөлс 3750.0 мянган төгрөгийг цалингийн төсвөөс олгосон, тээвэр шатахууны зардлаас 2,137.7 мянган төгрөгийг гэрэл цахилгааны төлбөр төлж, төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>3</sup>, 16 дугаар зүйлийн 16.5.5<sup>4</sup>, 41 дүгээр зүйлийн 41.2.2<sup>5</sup>, 41.2.3<sup>6</sup>, Засгийн газрын 2021 оны 43<sup>7</sup> дугаар тогтоолын 1.4<sup>8</sup>-т заасныг зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

3. Шилэн дансны цахим системд цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8 зарлагын гүйлгээний 210,000.0 мянга, урсгал санхүүжилтийн 37 гүйлгээний 691,437.5 мянган төгрөгийг мэдээллийг тус тус мэдээлээгүй, 34 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4<sup>9</sup>, 6.4.5<sup>10</sup>-т заасныг зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна;

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын дотоод журамд заасныд дагуу албан хаагчид болон ахмадуудад 2,400.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн боловч тушаал шийдвэрээр баталгаажуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлэхдээ тушаал гаргаж, хөнгөлөлтөд хамрагдсан албан хаагчдын нэрийг хавсралтаар батлах,

#### 2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс хүчингүй болсон эрх зүйн акт үндэслэн 43,670.6 мянган төгрөгийг зарцуулжээ.

Өгсөн зөвлөмж: Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн, Засаг даргын захирамж, тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг нягтлан, өөрчлөлт орсон эрх зүйн актын талаар албан хаагчдад тухай бүр мэдээлэл, сургалт хийж байх

<sup>2</sup> .төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

<sup>3</sup> төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

<sup>4</sup> Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

<sup>5</sup> батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

<sup>6</sup> .төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

<sup>7</sup> Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

<sup>8</sup> энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;

<sup>9</sup> таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

<sup>10</sup> цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

### 3. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тээвэр шатахууны төсвөөс 10,100.8 мянган төгрөгийн шатах тослох материалын зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар үнэн зөв, бүрэн гүйцэт гаргаж тайлагнаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу иж бүрэн, үнэн зөв хөтөлж, тооцоог бодож, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.5-д холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж, баталгаажуулах;

### 4. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Урсгал засварын зардлаас 1,200.0 мянган төгрөгийн гэрэл цахилгааны материал худалдан авч материалын дансанд орлого авч, зарлага болгоогүй шууд зардалд илэрхийлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан материалыг холбогдох эдийн засгийн ангиллын дагуу данс бүртгэлд тусган захиран зарцуулж байх ;

### 5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 75 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнххаан ЗДТГ	13	136,593.2	5	53,184.1	1	150.0	3	25,887.7	4	57,371.4
	ДҮН	13	136,593.2	5	53,184.1	1	150.0	3	25,887.7	4	57,371.4